

Компаний үйл ажиллагааны талаар: Үндэсний үйлдвэрлэгч ”Түмэн шувуут” ХКомпани нь үйл ажиллагаагаа өргөтгөн Хөдөө аж ахуйн цогц төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс IPO гаргасан ба нийт 3000 гаруй хувьцаа эзэмшигчтэй олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон.

Манай шувууны аж ахуй 2019 оны хагас жилийн байдлаар шувууны аж ахуй нь 350,000 өндөглөгч тахиатай үйл ажиллагаагаа явуулж байгаа ба өдөрт 170,000 ширхэг өндөг үйлдвэрлэн 10 гаруй нэр төрлийн савлагаатайгаар худалдан борлуулж байна.

Тус шувууны аж ахуй нь 2019 он гарсаар нийт 40,000 дэгдээхэй бойжуулан өндөглөгчийн тоо толгойг нэмэгдүүлсэн ба энэ сүрэг нь шинээр нэмж байгуулах Өндөглөгчийн 8-р байранд байрлана. Ийнхүү үйлдвэрийн хэмжээ 15-20 хувиар мөн нэмэгдэнэ.

Мөн бид өөрсдийн шувууны аж ахуйн тэжээлийн хэрэгцээг хангахаас гадна хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, малчдад зориулан Амар, Бондгор, Шингүүртэй овъеос, Хурд, Тарга, Сүүт нэрийн бог бод малын тэжээл мөн шувууны 5 төрлийн тэжээл болон гахайн тэжээлийг үйлдвэрлэн гаргаж байна. Эдгээр тэжээлийн түүхий эдийг дотоодоос худалдан авахын зэрэгцээ ОХУ-с импортлон авдаг.

Хөдөө аж ахуйн цогц шийдэл төслүүд төлөвлөгөөний дагуу эхлэн амжилттай хэрэгжүүлэн явж байна. Үүнд:

Хан-Уул дүүрэг дэх өндөглөгчийн тахианы аж ахуйг өргөтгөх үүднээс нэмж Өндөглөгчийн 8-р байр барих ба барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт зарлан сонгосон бөгөөд барилгын ажил 05 сарын 01-ний өдөр эхэлж, одоогийн байдлаар барилгын гүйцэтгэл 80 хувьтай явж байна. Тус өндөглөгчийн байрны тоног төхөөрөмжийг импортоор оруулан ирж угсралтын ажил хийгдэж байна.

Сонгинохайрхан дүүргийн 27 хороонд байрлах төв оффисын барилгыг буулган уг суурин дээр нь өндөг боловсруулах үйлдвэр болон агуулах барихаар төлөвлөсөн нь мөн хэрэгжиж эхэлсэн бөгөөд барилгын гүйцэтгэлийн ажил 70 хувьтай байгаа ба 10 сарын эхээр бүрэн ашиглалтад орох юм.

Шинээр байгуулах 200,000 шувуутай тахианы аж ахуйг Сонгинохайрхан дүүргийн 21 хороо, Их булаг хэмээх газар барихаар шийдвэрлэсний дагуу 20 га газар худалдан авсан ба эхний ээлжинд цахилгаан эрчим хүч, усны хангамжийн асуудлуудыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад нь хандаад байна.

Шувууны аж ахуйгаас хаягдал болон гарч байгаа сангасыг органик бордоо болгон үйлдвэрлэж, газар тариалангийн салбарт хувь нэмэр оруулах үүднээс бордооны үйлдвэр байгуулахаар шийдсэн ба уг ажил ч мөн хэрэгжилтийн шатандаа явж байна. Өөрөөр хэлбэл Японы компанитай хамтран ажиллах гэрээ байгуулсаны дагуу бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмжийг оруулж ирэхэд бэлэн болсон төдийгүй үйлдвэрийн барилгын ажил мөн эхлээд байна.

“Түмэн шувуут” ХКомпани нь зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулахаас гадна хөдөө орон нутаг тэр тусмаа алс холын Увс аймгийн Баруунтуруун суманд байрлах “Усжуулах” ХК-ний 4000 га газарт хиймэл нуурын усжуулалтын системд хөрөнгө оруулалт хийн сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсний үндсэн дээр усалгаат газар тариаланг хөгжүүлж байна.

Энэхүү бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 05 сараас 06 сарын хооронд 700 гаруй га газрыг орчин үеийн усалгааны тоног төхөөрөмжөөр тоноглон бүрэн ашиглалтад орууллаа. Энэ жилийн тухайд 473 га-д улаанбуудай тариалж байна.

Компаний үйл ажиллагаа амжилттай, өсөн нэмэгдэж байгаад ажилтан бүрийн хичээл зүтгэл, хүч хөдөлмөр ихээхэн ач холбогдолтой тул компаний гүйцэтгэх удирлагын зүгээс үйлдвэрийн ажилчдын цалинг 2019 оны 06 сарын 01-ний өдрөөс эхлэн 200 000 төгрөгөөр

нэмэхээр шийдвэрлэсэн юм. Цаашид ч мөн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа ажилтан бүрийн цалинг нэмэхээр төлөвлөж байна.

Удирдлагын талаар: “Түмэн шувуут” ХКомпани нь Л.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Э.Баяржаргал гэсэн 4 хувь нийлүүлэгчтэй байсан бол нээлттэй хувьцаат компани болсоноор 2019 оны 04 сарын 29-ний өдөр анхны Хувьцаа Эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж компаний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг энгийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн нийт 9 гишүүнтэй байхаар баталсан ба ТУЗ-ийн энгийн гишүүнээр Л.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Э.Баяржаргал, хараат бус гишүүнээр Ц.Наран-Учрал, Ц.Лут-Очир, О.Мөнхжаргал, Ц.Рэнчинсэнгээ, Э.Жаргалхүү нар тус тус сонгогдсон.

ТУЗ анхны хурлаараа ТУЗ-ийн даргаа сонгохоос гадна ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмыг хэлэлцэн баталж, мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог тус тус байгуулсан. ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр ТУЗ-ийн даргаар Л.Эрхэмбаярыг сонгосон ба компаний гүйцэтгэх удирдлагаар Ж.Болдыг хэвээр нь томилохоор шийдвэрлэлээ.

Санхүүгийн байдлын талаархи мэдээлэл: “Түмэн шувуут” ХК нь 2019 оны эхний хагас жилд нийт 170 гаруй ажилтантайгаар өндөглөгч тахианы аж ахуй, малын тэжээлийн үйлдвэрлэл, өндөгний сав баглааны үйлдвэрлэл гэсэн байнгын ажиллагаатай 3 үйлдвэрт бүтээгдэхүүн үйлдвэрлэж ажилласан нь 2018 оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлийн тоо хэмжээ, борлуулалтын орлого зэргийг 28 хувиар өсгөсөн амжилттай ажилласан байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэл:

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Өндөг	ширхэг	31,57 сая
2	Шувуу болон малын тэжээл	тонн	5,6 мян
3	Дэгдээхий	толгой	40 мян
4	Өндөгний цаасан сав	ширхэг	2 сая

2019 хагас жил хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулахад онцгойлон анхаарч, үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний үнийг боломжит түвшинд барьснаар ашигт ажиллагааг өнгөрсөн оны мөн үеэс 72 хувь өсгөсөн байна.

Санхүүгийн үзүүлэлт:

№	Үзүүлэлтүүд	Мөнгөн дүн
1	Борлуулалтын орлого	10,456 сая
2	Цэвэр ашиг	2,067 сая

МУ-ын хууль тогтоомжийн дагуу “Түмэн шувуут” ХХ нь цаг хугацаандаа татвараа үнэн зөвөөр тайлагнаж, татвараа бүрэн төлсөн.

Төлсөн татвар хураамж: 2019.06.30 өдрийн байдлаар

№	Татвар хураамж	Мөнгөн дүн
1	НӨАТ	812,777 сая
2	Гааль	140,981 сая
3	ААНОАТ	296,487 сая
4	ХАОАТ	129,552 сая
5	НДШ	317,135 сая
6	ҮХХ	13,176 сая
7	Бусад	27,348 сая
	Нийт	1,737,456 сая

“Түмэн шувуут” ХКомпани нь цаашид үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хүний биеийн эрүүл мэндэд онцгой ач тустай иод болон омега-3-аар баяжуулсан шинэ нэр төрлийн ИОДТОЙ ӨНДӨГ, ОМЕГА-3-ТАЙ ӨНДӨГ нэрийн бүтээгдэхүүн гаргахаар судалгаа шинжилгээний ажил хийгдэж байна.

-----oO-----